**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН**
**“МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-III”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД**
**ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2021-2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ**
**2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

**2021 оны 11 дүгээр сарын 30** **Багануур дүүрэг**

| Д/д | Засгийн газрын 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны заалтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2020) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|
| 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, бэлтгэлийг бүрэн хангахад хөтөлбөрийн зорилго оршино. | | | | | | |
| Зорилт 2. Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх | | | | | | |
| 1. | 3.2.15 дахь заалтын хүрээнд: Байгууллага хамт олноороо “Монгол бичигтэн болцгооё” аяныг өрнүүлэх | - | Монгол бичгийн үг зүй шалгах тестийн хувь | - | Анхан шатны мэдлэг шалгах үг зүйн тестийг боловсруулж, бүх албан хаагчдыг хамруулна. Тестийн хувь 80-аас дээш байна. | ✓ Монгол бичгийн анхан шатны 10 асуулт бүхий тестийг боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр бүх албан хаагчдаас тест авахад ажилтнууд 1-2 алдаж нийт дунджаар 82%-ийн үзүүлэлттэй гарсан.<br>“Үр дүнтэй”<br>100% |
| 2. | 3.2.15 дахь заалтын хүрээнд: Байгууллага дотроо “Цэвэр бичигтэн” шалгаруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийг монгол бичгээр цэвэр бичсэн 1 ажилтанг шалгаруулна.<br>100% | ✓ Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгээс албан хаагчид өөрт таалагдсан 8 мөрийг монгол бичгээр бичих ажлыг нийт ажилтнуудын дунд зохион байгуулж, 10 дугаар сарын 29-ний өдөр шалгаруулалт явуулахад, олонхийн саналаар Бичиг хэрэг архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн цэвэр бичигтнээр тодорсон.<br>“Үр дүнтэй”<br>100% |
| Зорилт 3. Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | 3.3.4 дэх заалтын хүрээнд: Албан хаагчийн албан тушаалын тодорхойлтод тавигдах шаардлагад монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусгах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Албан хаагчийн албан тушаалын тодорхойлтод тавигдах шаардлагад монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусгасан байна. | ✓ Албан хаагчийн албан тушаалын тодорхойлтод тавигдах шаардлагын “бусад” хэсэгт монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусган БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар баталж, нийт ажилтнуудад танилцуулсан.<br>“Үр дүнтэй”<br>100% |
| 6. | 3.3.5 дахь заалтын хүрээнд: Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын сургалтын хөтөлбөрт ажилтны монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг жил бүр төлөвлөх, тайлагнах | | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | Монгол бичгийг албан хаагчдаар бие даан судлуулна.<br><br>Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ыг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөөг 2 жилд 1 удаа баталж, хэрэгжилтийг ханган тайланг хагас, бүтэн жилээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. | ✓ Албан хаагчид цахим орчинг ашиглан 05-09 дүгээр сарууддад монгол бичгийн мэдлэгийг сэргээж бие даан судалсан.<br>✓ Дүүргийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран албан хаагчдад монгол бичгийн мэдлэг олгох дунд шатны 8 цагийн сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Албан хаагчид монгол бичгийн мэдлэгээ сэргээн сайжруулж, дунд шатны түвшинг эзэмшсэн маш үр дүнтэй сургалт болсон. Цаашид тус төвтэй хамтран сургалтыг тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>✓ НЗДТГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 03/1665 дугаартай албан бичгийн дагуу “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021-2022 оны тусгай төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр заасан хугацаанд нь тайлагнан ажилласан.<br>“Үр дүнтэй”<br>100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох | | | | | | |
| 3. | 3.4.8 дахь заалтын хүрээнд: Үндэсний өв соёл босоо бичгийн талаарх сурталчилгааг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд түгээх | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Олон нийтийг монгол бичиг сурах эрмэлзэл, өв соёлоо хадгалах хамгаалах төлөвшилд уриална. | ✓ Байгууллагын цахим хуудасны “Мэдээ” цэсэнд “Эх хэл соёлоо дээдлье” дэд цэсийг нэмж монгол бичгийн мэдлэгийг бататгах мэдээлэл, дүрмийг байршуулж ажилласан.<br>Нийт байршуулсан мэдээлэл-69<br>Мэдээллийг үзсэн тоо-178<br>“Үр дүнтэй”<br>100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э. ЭНХЗАЯА